



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/31

Ховд

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон сумдын хөдөө аж ахуйн тасгийн бүтэц, орон тоог батлах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.5, 16.6, 16.8 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц, орон тоог 1 дүгээр хавсралтаар, сумдын Хөдөө аж ахуйн тасгийг 3 хүний орон тоо, чиг үүрэгтэйгээр шинэчлэн зохион байгуулж тасгийн бүтцийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтцийн нэгж, албан тушаалтанд төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоосон төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээний холбогдох шатлалын дагуу цалин, бусад нэмэгдэл олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Г.Гончигсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн бүтцийн нэгжийн албан тушаалтанд төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоосон төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээний холбогдох шатлалын дагуу цалин, бусад нэмэгдэл олгохыг сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/515 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 00165
Zah-A/31-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 21-ний өдрийн
А/31 дүгээр захирамжийн
1 дүгээр хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

| Бүтцийн нэгж | Албан тушаал | Цалингийн сүлжээний шатлал | Орон тоо |
|--------------------------------------|---|----------------------------|-----------|
| 1 | 2 | 3 | 4 |
| Газрын дарга | | T3-9 | 1 |
| Захиргаа, аж ахуйн алба | Албаны дарга (Хөдөө аж ахуйн ололт нэвтрүүлэлт хамтын ажиллагаа хариуцна) | T3-7 | 1 |
| | Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Ахлах нягтлан бодогч | TY-8 | 1 |
| | Техник хэрэгсэл, программ, сүлжээ, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн | TY-7 | 1 |
| | Архив-бичиг хэрэг, няравын ажил хариуцсан мэргэжилтэн | TY-5 | 1 |
| | Жолооч | TY-3 | 1 |
| | Үйлчлэгч | TY-1 | 1 |
| | Сахиул, сантехникч | TY-1 | 1 |
| | Нийт | | 10 |
| Мал үржлийн алба | Албаны дарга бөгөөд аймгийн Ерөнхий мал зүйч, (мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, технологийн хяналтын асуудал хариуцна) | T3-7 | 1 |
| | Малын генетик нөөцийн ашиглалт, эрчимжүүлэлт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн асуудал, тайлан, мэдээ хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Малын удмын зүйн үнэлгээ, цөм сүрэг, үүлдэр, ашиг шимийн сайжруулалт, үржүүлэг технологийн ажил үйлчилгээ, итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, ялган тэмдэглэгээ хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Нийт | | 5 |
| Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний алба | Албаны дарга (бүтцийн нэгжийн аль нэг мэргэжилтний чиг үүрэг хамаарах асуудлыг давхар хариуцна) | T3-7 | |
| | Газар тариалангийн үйлдвэрлэл, техник, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоол, худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн | T3-5 | 1 |
| | Нийт | | 3 |
| | Бүгд | | 18 |

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 21-ний өдрийн
А/31 дүгээр захирамжийн
2 дугаар хавсралт

СУМДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН АЛБАН ТУШААЛТНЫ
ХАРИУЦАХ ЧИГ ҮҮРЭГ, ОРОН ТОО

| № | Сумын нэр | Цалингийн сүлжээний шатлал | Орон тоо | | | Нийт орон тоо |
|----|-------------|----------------------------------|--|--|---|---------------------|
| | | | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Хүнс, Жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн | Бэлчээр тэжээл, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн | |
| 1 | Алтай | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 2 | Булган | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 3 | Буянт | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 4 | Дарви | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 5 | Дөргөн | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 6 | Дуут | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 7 | Зэрэг | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 8 | Манхан | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 9 | Мянгад | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 10 | Мөст | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 11 | Мөнххайрхан | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 12 | Үенч | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 13 | Ховд | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 14 | Цэцэг | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 15 | Чандмань | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 16 | Эрдэнэбүрэн | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| 17 | Жаргалант | T3-3 | 1 | 1 | 1 | 3 |
| | Бүгд | | 17 | 17 | 17 | 51 |

-oOo-